БАТЛАВ.
ЕРӨӨ СУМЫН ЗАСАГ ДАРГА
Э. ОДГАРАВ

2024 оны 12 дугаар сарын 20

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЕРӨӨ СУМЫН ОЙН САНГИЙН ТАЛБАЙД ЗАГВАР ОЙД АРЧИЛГААНЫ АРГА ХЭМЖЭЭ ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ДААЛГАВАР, ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Ажил гүйцэтгэх талбай: Ерөө сумын ойн сангийн талбайн 103 дугаар хэсэглэлийн 4, 5, 6, 7, 10, 13 дугаар ялгаралд нийт 100 га талбайд ойн арчилгааны арга хэмжээ хэрэгжүүлнэ.

Ойн арчилгааны арга хэмжээ /гэрэлжүүлэх/- I багц 100 га / Дөхөм/

1 га арчилгааны гэрэлжүүлэх огтолтын зардал 400 000 төгрөг ба нийт 40000000 төгрөг байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас санхүүжүүлнэ. Тендэрт оролцогч нь дор дурьдсан шаардлагыг хангасан төсөл боловсруулна.

АРЧИЛГААНЫ АЖИЛ ХИЙХ ГАЗРУУД, ГҮЙЦЭТГЭХ АЖЛЫН АГУУЛГА ҮЕ ШАТУУД

Сэлэнгэ аймгийн Ерөө сумын ойн сангийн насны 1 болон дүгээр ангийн 100 га талбайд арчилгааны арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Ойн арчилгааны ажил нь бэлтгэл, арчилгааны ажлыг гүйцэтгэх, талбайг хүлээлгэн өгөх, зөрчил, гологдол арилгах, тайлан боловсруулах, тайланг хэлэлцүүлэн хүлээлгэн өгөх гэсэн үе шатуудтай байна.

БЭЛТГЭЛ

- Ойн арчилгааны ажил гүйцэтгэх улирлын болон түр ажилчдыг дадлагажуулах;
- Ойн арчилгааны ажилд хэрэглэгдэх техник, тоног төхөөрөмжүүдийн засвар үйлчилгээг бүрэн хийн ажилд гарахад бэлэн болгох;
- Ойн арчилгааны ажил гүйцэтгэх талбайг сонгох, талбайг тусгаарлах, /Талбай тусгаарлалтын баримт бичиг боловсруулах, тусгаарласан талбайг хүлээн авах, хүлээлгэн өгөх/;
- Ойн арчилгааны ажлын технологийн карт, ажил гүйцэтгэх графикчилсан төлөвлөгөө боловсруулах, хянуулж баталгаажуулах;
- Ойн арчилгааны ажлыг гүйцэтгэх улирлын болон түр ажилчдад ажил гүйцэтгэх технологи болон хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны талаар заавар, зааварчилгаа, техник, багаж хэрэгсэлтэй ажиллах заавар зөвлөмжийг бэлтгэн өгөх;
- Ойн арчилгааны ажлыг гүйцэтгэх улирлын болон түр ажилчдад ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх талаар анхааруулга өгөх;

ОЙН АРЧИЛГААНЫ АЖИЛ ХИЙХ

- "Ойд арчилгаа, цэвэрлэгээ хийх журам", "Ойд арчилгааны ажил хийх технологийн заавар"-ыг мөрдлөг болгон ажиллах
- Ойн арчилгааны ажлыг гэрээ байгуулснаас хойш 10-р сарын 20-ны дотор хийх;

- Ойн арчилгааны ажлыг батлагдсан технологийн карт, графикчилсан төлөвлөгөөг боловсруулан ажилчдад танилцуулах, мөрдөж ажиллах;
- Арчилгааны ажил хийсэн талбайн шон, тэмдэгжүүлэлт, шон дээрх бичилтийг хийх, /шонд нүүр гаргаж талбай руу харсан талд арчилгаа хийсэн он, сар, өдөр, талбайн хэмжээ, арчилгааны хэлбэр зэргийг бичнэ/;
- Ойн арчилгааны ажлаас гарсан модыг талбайн захад хурааж овоолон арчилгаа хийсэн талбайг цэвэрлэх

ТАЛБАИГ ХҮЛЭЭЛГЭН ӨГӨХ

Ойн арчилгааны ажил хийгдсэн талбайг захиалагчаас томилогдсон ажлын хэсэг, төслийн менежер, орон нутгаас томилогдсон ажлын хэсэгт актаар хүлээлгэн өгөх ажлыг зохион байгуулна. Аймаг, нийслэлийн Засаг даргын томилсон ажлын хэсгийн гаргасан актыг үндэслэн хүлээн авна. Дараах нөхцөлийг хангасан үед уг ажлын гүйцэтгэлийг хангалттай гэж үзэн хүлээн авна. Үүнд:

- Ойн арчилгааны ажил хийх талбайг зөв сонгосон, талбай тусгаарлалт хийж хилийн шон, тэмдэг, тэмдэглэгээ, чиг огтлолт хийсэн, жишиг талбай, ажлын болон хяналтын талбай байгуулсан, авах шаардлагатай модыг тэмдэглэсэн эсэх, технологийн карт боловсруулсан, арчилгааны ажил хийсэн талбайн хил дээрх шонд нүүр гаргаж талбай руу харсан талд арчилгаа хийсэн он, сар, өдөр, талбайн хэмжээ, арчилгааны хэлбэр зэргийг бичсэн, арчилгааны ажлыг давтан гүйцэтгэж байгаа тохиолдолд, талбайд шинэ шон зоохгүй, хуучныг засаж бичсэн, мөчрийн цэвэршилтийн арчилгаа хийсэн, арчилгаанаас гарсан модыг талбайгаас гаргаж хураан, арчилгаа хийсэн талбайг цэвэрлэсэн байх.
- Арчилгаа хийсэн талбайг тухайн сумын ойн сангийн тархалтын зураг болон ойн аж ахуйн арга хэмжээний зурагт тэмдэглэсэн, арчилгаа хийсэн тухай харъя ойн ангийн тодорхойлолт байх.
- Ойн арчилгааны ажлын технологийн карт, ажил гүйцэтгэх графикчилсан төлөвлөгөөг бүрэн гүйцэд дагаж мөрдсөн байх.

Ойн арчилгааны ажлыг хүлээн авахдаа гэрээний ерөнхий ба тусгай нөхцөлийн дагуу зөрчил, гологдлыг арилгасны дараа захиалагч байгууллагаас томилогдсон ажлын хэсэгт эсхүл тухайн орон нутгийн засаг даргын томилсон комисст хүлээлгэн өгсөн акт болон төслийн менежерийн дүгнэлтийн дагуу хүлээн авна.

ЗӨРЧИЛ, ГОЛОГДОЛ АРИЛГАХ	• Техникийн тодорхойлолтод заасан ойн арчилгааны ажлын гүйцэтгэл шалгуурт хүрээгүй тохиолдолд ажлыг үр дүнг шалгуурт хүртэл дахин хийлгүүлэн дараа жилийн намар актаар хүлээн авах • Техникийн тодорхойлолтод заасан ойн арчилгааны ажлын гүйцэтгэл хангалтгүй гэж үзвэл гүйцэтгэгчээр ажлын урьдчилгааг эргүүлэн төлүүлэх
ТАИЛАН БОЛОВСРУУЛАХ	Ойн арчилгааны ажил гүйцэтгэсэн тайланг захиалагчид 3 хувь ирүүлнэ. Тайлан дор дурдсан бүрдэл хэсгүүдээс бүрдэнэ. Үүнд: а/ Ойн арчилгааны ажил гүйцэтгэсэн тайлан; Ойн арчилгааны ажлын үе шат тус бүрээр хийсэн ажлын гүйцэтгэл, ажлын технологийн дараалал, ажил гүйцэтгэсэн хугацаа, ажиллах хүчин, ажлын өдөр тутмын гүйцэтгэл, тавьсан хяналт зэрэг мэдээллийг багтаана. Дээж талбайн тооллого болон бусад судалгааны ажлын үед авсан гэрэл зураг, ойн төлөв байдлын зураг, ойн арчилгааны ажил хийсэн талбайн ерөнхий байдлын зураг, эхлэл төгсгөлийн зургийг харьцуулсан байдлаар фото хэлбэрээр тайланд хавсаргана. б/ 1:50 000 болон түүнээс том масштабтай ойн арчилгааны ажил явуулсан талбайн зураг; Хэсэглэл, ялгарлын хил, дугаар, талбай, газрын төрлийн ангилал тэмдэглэгээ, модны төрөл, насны бүлэг, газар ус, уул, өндөрлөг тоотын нэр, газар зүйн байрлалын солбицлын торлол, зургийн масштаб, проекц, таних тэмдэг эдгээрийг ой зохион байгуулалтын технологийн зааварт заасан стандартын дагуу гүйцэтгэж оруулна. в/ Тухайн орон нутгийн Засаг даргын ажлын хэсэг байгуулсан шийдвэрийн хуулбар, ажлын хэсэгт гүйцэтгэсэн ажлыг хүлээлгэн өгсөн актын хамт. Тайланг захиалагчийн томилсон ажлын хэсгийн хурлаар хэлэлцүүлэн хүлээлгэн өгнө. Хэрэв тайланд зөрчил гологдол илэрсэн бол түүнийг арилгах үүргийг гүйцэтгэгч хүлээнэ. Зөрчил гологдлыг арилгасан тухай төслийн менежер мэдэгдэл гарган дахин захиалагчийн томилсон ажлын хэсгийн хурлаар хэлэлцүүлэн хүлээн авсны дараа эцсийн шатны санхүүжилтийг олгоно.
ТАИЛАНГ ХЭЛЭЛЦҮҮЛЭН ХҮЛЭЭЛГЭН ӨГӨХ	Ойн арчилгааны ажлын тайланг “ЕБСД-ын Ойн ангид 3 хувийг хүргүүлнэ. Тайланг зөвшөөрөх хугацааг ажлын үе шатны хуваарьт тусгасан болно.
МЭРГЭШСЭН ИНЖЕНЕР ТЕХНИКИЙН АЖИЛЧДЫН ХАНГАМЖИД ТАВИГДАХ ШААРДЛАГА	Ойн арчилгааны ажлыг зохион байгуулахад мэргэшсэн инженер техникийн болон улирлын ажилтнууд нь доорх шаардлагуудыг хангасан байна. Үүнд: Ерөнхий инженер нь ойн арчилгааны ажил буюу гэрээгээр заасан ажилтай төрөл, үнийн дүнгээрээ ижил ажил гүйцэтгэсэн 3 жилийн туршлагатай байх, түүн дотроо гэрээг бие даан хариуцаж ажилласан 2 жилийн туршлагатай байх

Инженер, техникийн ажилтан нь ойн арчилгааны ажил буюу гэрээгээр заасан ажилтай төрөл, үнийн дүнгээрээ ижил ажил гүйцэтгэсэн 2 жилийн туршлагатай байх

Ойн арчилгааны ажлыг зохион байгуулахад бусад шаардлагатай ажилчидтай /тогооч, жолооч гэх мэт/ байх

Зураг төслийн жагсаалт /тендерт оролцогч ирүүлэх/

д/д	Зураг төслийн нэр	Агуулга
1.	Ойн арчилгааны ажил явуулах талбайн зураг	Ойн арчилгааны ажил гүйцэтгэх арга технологи тус бүрээр газар нутгуудыг тэмдэглэх, ажил гүйцэтгэх хугацааг харуулсан байх
2.	Ойн арчилгааны ажилд ашиглах багажийн зураг	Багажийн маркийг бүрэн гүйцэд харуулсан байх
3.	Ойн арчилгааны ажилд ашиглах автомашинуудын зураг	Ажилд ашиглах автомашинуудын зургийг тус бүрд нь харуулах
4.	Ойн арчилгааны ажилд ажиллах гар багаж, техник тоног төхөөрөмжийн тоо	Тоо хэмжээг бүрэн харуулсан байх

ҮЕ ШАТНЫ АЖЛЫН ХУВААРЬ

д/д	Ажлын нэр, тодорхойлолт	Тоо, хэмжээ	Нийлүүлэх хуваарь
1	Бэлтгэл ажил	100 га	2025.06.10-ны дотор
2	Ойн арчилгааны ажил хийх	100 га	2025.06.10-с 2024.10.01 хүртэл
3	Талбайг хүлээлгэн өгөх	100 га	2025.10.10-ны дотор
4	Зөрчил, гологдол арилгах	100 га	2025.10.15-ний дотор
5	Тайлан боловсруулах	100 га	2025.10.20-ны дотор
6	Тайланг хүлээлгэн өгөх	1 удаа	2025.11.01-ны дотор

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЕРӨӨ СУМЫН ОЙН САНД АРЧИЛГААНЫ АРГА ХЭМЖЭЭГ ХЭРЭГЖҮҮЛЭХ

д/д	Сумын нэр	Ойн арчилгааны ажил явуулах			ОЗБ хийсэн огноо	Арчилгааны хэлбэр
		Талбай, га	Газрын нэр	Хэсэглэлийн дугаар		
	Сэлэнгэ аймаг Ерөө сум					
1	Ерөө сум	100	Хожуултын даваа	103	2017	Гэрэлжүүлэх /сонгон зурах/
	ДҮН	**100**	**-**		**-**	**-**


СЭЛЭНГЭ аймаг ЕРӨӨ сум
ЗАГВАР ОЙН ТАЛБАЙН ЗУРАГ
Газрын нэр: Хожуултын даваа
Хэсэглэлийн дугаар: 103
Ялгарлын дугаар: 4, 5, 6, 7, 10, 13
Талбайн хэмжээ: 100 га
Ой зохион байгуулалт 2019 он
Таних тэмдэг
Хэсэглэлийн хил
100га ойн талбайн хил
100га ойн блокын дугаар
Ялгарлын хил
Ойн талбайн төрөл
Залуу хусан ой
Болц гүйцэж буй хусан ой
Болц гүйцэж буй нарсан ой
Залуу улиангар
Тармаг нарсан ой
Ойжуулсан талбай
Цагаан энгэр
103
Зургийн тусгаг: WGS_1984_UTM_Zone48
0 100 200 400 600 800 Meters
Масштаб: 1:10,000
1 cm = 100 meters
Зургийг боловсруулсан: ЕСДОА

Хавсралт

ОЙН АРЧИЛГААНЫ АЖЛЫН ТЕХНОЛОГИЙН ДАРААЛАЛ

№	Хийх ажилбаруудын дараалал	Хэмжих нэгж
1	2	3
1.1	Арчилгаа хийх ойг сонгох	га
1.2	Ойн арчилгаа хийх талбайг тусгаарлаж шон хатгах, тэмдэглэгээ хийх	га
1.3	Ойд тооллого хийх, жишиг талбай байгуулах	га
1.4	Талбай тусгаарлалтын баримт бичиг боловсруулах	га
1.5	Ойн арчилгааны огтлолт гүйцэтгэх	га
1.6	Арчилгаа хийсэн талбайг цэвэрлэх	га
1.7	Арчилгаа хийсэн талбайг хүлээлгэн өгөх	га
1.8	Тайлан боловсруулах	га
1.9	Тайлан хүлээлгэн өгөх	га

АЖЛЫН ДААЛГАВАР БОЛОВСРУУЛСАН:
ЕРӨӨ БҮСИЙН СУМ ДУНДЫН
ОЙН АНГИЙН ИНЖЕНЕР Н.БУЯНДЭЛГЭР